



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 04


Эрдэнэбулган сум

Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах,
зудын гамшгаас урьдчилан сэргийлэх тухай

Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар “Өвөлжилтийн бэлтгэх хангах тухай” албан даалгаврыг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх, зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, хүйтний улиралд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасалдалгүй, түргэн шуурхай хүргэх бэлэн байдлыг хангах зорилгоор дараахь албан даалгаврыг хүргүүлж байна. Үүнд:

1. Түргэний машины техникийн бэлэн байдал, найдвартай ажиллагааг хангаж, түргэн тусламжинд цаг алдалгүй шуурхай үйлчлэх
2. Бага оврын халаалтын зуухаар ажилладаг эрүүл мэндийн байгууллагууд нүүрс, түлээний 30 хоногоос доошгүй хугацааны байнгын бэлэн нөөцтэй байх
3. Уурын зуухны халаалтын тогоо, халаалтын шугамны бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг шалгаж, бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг өөрсдийн боломжинд тулгуурлан шийдвэрлэж, халаалтын доголдол гаргахгүй ажиллах
4. Яаралтай тусламжийн эм, тариа, ороох боох материалын хангалт, нөөцийг нэмэгдүүлэх, яаралтай тусламжийн эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 1-2 сарын тогтмол нөөцтэй байж, тасалдал гаргахгүй байх
5. Түргэн тусламжийн эмч, жолооч нарыг дулаан хувцасаар хангах
6. Түргэн тусламжийн дуудлаганд яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, тариа, ороох боох материал, багаж, тоног төхөөрөмжийг бүрэн авч явж байх
7. Багийн эмч нарын яаралтай тусламжийн эм, хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх
8. Яаралтай тусламжийн талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт хийх
9. Хөдөөгийн багт байгаа 0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмнэлгийн хяналтанд байдаг архаг өвчтэй иргэдийн судалгааг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор гаргах

1. Хөдөөгийн багуудын айл, өрхийг наад захын хэрэглээний эм, ороох, боох материал, халууны шил, даралтын аппараттай болгох, хэрхэн хэрэглэх талаар заавар, зөвлөгөө өгөх
2. Сумын төвөөс алслагдмал айл, өрхүүдийн архаг өвчтэй хүмүүсийн хяналтыг сайжруулах, тогтмол хэрэглэдэг эмнүүдийн нөөцтэй болгох /даралт ихэсдэг хүмүүсийг таарч тохирсон даралтын эмний нөөцтэй болгох гэх мэт/
3. Хөлдөлт, осголтоос урьдчилан сэргийлэх, хөлдөлт, осголтын үед өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэх талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгааг ард иргэд, эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдэд хийх, гарын авлага, зөвлөмжөөр хангах
4. Төрөх эхчүүдийг хүлээн авах эхийн амрах байрны бэлэн байдлыг хангах
5. Сумын төвөөс алслагдмал айл өрхүүдийн бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүд, асран хамгаалагч нарт хүүхдэд тусламж хайх мэдлэг олгох сургалт, сурталчилгаануудыг зохион байгуулан, өвчлөл, хүндрэлээс сэргийлэх
6. Өвөлжилтийн бэлэн байдал, зудын нөхцөл байдалтай холбоотой ЭМЯ, аймгийн ЗДТГ, ЭМГ-аас шуурхай авах мэдээ, тайлангуудыг тухай бүр хугацаанд нь шуурхай, үнэн зөв гаргаж ирүүлж байх
7. Албан даалгаврын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлангаа 2020 оны 10 дугаар сарын 01-ны дотор ЭМГ-т ирүүлэх

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.АЛТАНТУЯА